СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2023/08-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: З.Золбоо Утас: 70362442 Цахим хаяг: zolbooz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл 5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга 10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан 19
4.1 Ерөнхий зүйл 19
4.2 Материаллаг байдал 20
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт 20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 22
5. Аудитын илрүүлэлт 23
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл 27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил , үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.БАТ-ОРХОН ТАНАА

2023.03.25 № СЭА-2023/08-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн 1,692,598.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 86.3 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 13.7 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Орхон сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 20.6 хувь буюу 339,965.9 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 400,941.6 мянган

018020375

төгрөг, хангамж, бараа материалын зардалд 34,416.8 мянган төгрөг, норматив зардалд 411.3 мянган төгрөг, тавилга эд хогшил, урсгал засварын зардалд 30,851.2 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 3,157.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 9,744.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 33,203.7 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгд 59,634.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 625,318.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тайлант онд сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэнээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**1,086,518.9**	**615,912.5**
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	662,150.8	404,873.4
33	АВЛАГА	171,666.4	177,370.5
35	БАРАА МАТЕРИАЛ	252,701.8	33,668.6
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**4,669,819.3**	**1,959,416.0**
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,669,819.3	1,959,416.0
39200	Биет хөрөнгө	4,600,339.2	1,929,970.6
39300	Биет бус хөрөнгө	69,480.0	29,445.4
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**5,756,338.1**	**2,575,328.4**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	70,810.2	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	70,810.2	-
41300	Өглөг	70,810.2	-
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**5,685,528.0**	**2,575,328.4**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	**5,685,528.0**	**2,575,328.4**
51100	Засгийн газрын оруулсан капитал	906,101.3	262,048.7
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	906,101.3	262,048.7
51200	**Хуримтлагдсан үр дүн**	**4,131,077.5**	**2,187,651.6**
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	648,349.2	125,628.1
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**5,756,338.1**	**2,575,328.4**

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**4,396,873.2**	**1,652,295.1**
11	ТАТВАРЫН ОРЛОГО	186,740.3	341,459.9
110	Орлогын албан татвар	34,547.8	130,089.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	34,547.8	130,089.7
113	Хөрөнгийн албан татвар	92,822.5	106,410.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	59,370.0	104,960.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,373,585.8	159,100.3
120	Нийтлэг татварын бус орлого	1,373,585.8	159,100.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,836,547.1	1,151,734.9
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**3,027,860.0**	**1,138,654.0**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,027,860.0	1,138,654.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,198,222.2	1,077,020.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,173,130.3	304,008.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,802.4	38,831.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	333,773.3	392,567.1
2104	Хангамж, бараа материалын зардал	80,392.7	48,520.1
2105	Норматив зардал	143,461.9	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,160.1	17,036.9
2107	Томилолт, зочны зардал	2,987.6	3,157.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,503.8	12,791.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	271,010.1	260,106.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	829,637.8	61,634.0
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)**	**1,369,013.2**	**513,641.1**
V	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН**	**178,586.9**	**3,661,668.6**
VI	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)**	**1,190,426.3**	**-3,148,027.6**

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	**2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**906,101.3**	**648,349.2**	**2,940,651.1**	**4,495,101.7**
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	906,101.3	648,349.2	2,940,651.1	4,495,101.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Тайлант үеийн үр дүн	-	-	1,190,426.3	1,190,426.3
7	**2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**906,101.3**	**648,349.2**	**4,131,077.5**	**5,685,528.0**
8	**2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл**	**906,101.3**	**648,349.2**	**4,131,077.5**	**5,685,528.0**
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-644,052.6	-522,721.1	1,204,601.7	37,828.0
10	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**262,048.7**	**125,628.1**	**5,335,679.2**	**5,723,356.0**
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
13	Тайлант үеийн үр дүн	-	-	-3,148,027.6	-3,148,027.6
14	**2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл**	**262,048.7**	**125,628.1**	**2,187,651.6**	**2,575,328.4**

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)**	**3,559,252.3**	**1,653,344.7**
11	ТАТВАРЫН ОРЛОГО	186,740.3	341,459.9
110	Орлогын албан татвар	34,547.8	130,089.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	34,547.8	130,089.7
113	Хөрөнгийн албан татвар	92,822.5	106,410.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	59,370.0	104,960.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,701.5	5,381.6
1181	Газрын төлбөр	28,596.0	71,922.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	24,072.5	27,655.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	546,193.5	162,401.6
120	Нийтлэг татварын бус орлого	546,193.5	162,401.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,826,318.4	1,149,483.2
II	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**2,738,174.7**	**968,826.9**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,738,174.7	968,826.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,893,031.9	907,193.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,167,925.1	304,897.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,089.4	37,168.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	282,129.2	400,941.6
2104	Хангамж, бараа материалын зардал	68,865.7	37,947.1
2105	Норматив зардал	133,969.4	411.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,943.9	22,621.6
2107	Томилолт, зочны зардал	2,987.6	3,157.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,784.4	15,985.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,337.3	84,062.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	845,142.8	61,634.0
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)**	**821,077.6**	**684,517.8**
V	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)**	**153,169.6**	**826,795.1**
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	153,169.6	826,795.1
2200	Дотоод эх үүсвэрээр	153,169.6	826,795.1
VI	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)**	**(153,169.6)**	**(826,795.1)**
VII	**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН**	**(89,000.0)**	**(115,000.0)**
VIII	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)**	**578,908.0**	**(257,277.4)**
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	83,242.7	662,150.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	662,150.8	404,873.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**1,915,311.4**	**1,652,645.8**	**262,665.6**	**86.3**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,023,848.0	912,326.9	111,521.1	89.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	961,677.3	852,692.9	108,984.4	88.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	347,431.1	302,797.8	44,633.3	87.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,054.1	37,168.1	10,886.0	77.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	441,519.2	400,941.6	40,577.6	90.8
2104	Хангамж, бараа материалын зардал	35,063.2	34,416.8	646.4	98.2
2105	Норматив зардал	411.3	411.3	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,102.9	30,851.2	5,251.8	85.5
2107	Томилолт, зочны зардал	3,169.4	3,157.6	11.8	99.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,462.5	9,744.9	5,717.6	63.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,463.6	33,203.7	1,259.9	96.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,170.7	59,634.0	2,536.7	95.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,170.7	59,634.0	2,536.7	95.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	741,463.4	625,318.9	116,144.5	84.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,000.0	115,000.0	35,000.0	76.7
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**1,915,311.4**	**1,692,598.4**	**222,713.0**	**88.4**
32	**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**1,758,061.4**	**1,598,034.0**	**160,027.4**	**90.9**
320001	Орон нутгийн төсвөөс	1,586,227.3	1,426,199.9	160,027.4	89.9
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	171,834.1	171,834.1	-	100.0
35	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	**157,250.0**	**94,564.4**	**62,685.6**	**60.1**
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	157,250.0	94,555.3	62,694.7	60.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9.1	(9.1)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	114,703.8	(114,703.8)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	154,656.4	(154,656.4)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	266,352.8
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	73,106.1
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	62,729.6
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	2,100.0
2104	**Хангамж, бараа материалын зардал**	3,530.3
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	6,240.1
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	50,859.2
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	10,376.5
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	2,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000.0
2133	**Олгосон санхүүжилт, шилжүүлэг**	8,376.5
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,376.5
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	193,246.7
2200	**Дотоод эх үүсвэрээр**	193,246.7
220001	Барилга байгууламж	26,604.1
221001	Их засвар	136,642.5
222001	Тоног төхөөрөмж	30,000.0
I	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	266,352.8
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	266,352.8
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,300.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	248,640.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,412.8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг "Хамтын зүтгэлээр Орхон нутгаа хөгжүүлье" гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,
- Аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн хяналтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах,
- Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж, эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулах,
- Төрийн үйлчилгээнд ухаалаг тогтвортой засаглалыг бэхжүүлж, чадахуйн зарчимд суурилсан хариуцлагатай шуурхай, нээлттэй, ил тод төрийн үйлчилгээг хүргэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2022 оны 194 дүгээр тогтоолоор "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт"-д өөрчлөлт оруулсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам" хэрэгжиж эхэлсэн,

- ХХААХҮС-ын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам" хэрэгжиж ирсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт нь оновчтой боловч хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ. Тайлант онд дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын ТТЗ-ийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяр хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Орхон сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,181,009.7 мянган төгрөгөөр буюу 55.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	662,150.8	404,873.4	-257,277.4
Авлага	171,666.4	177,370.5	5,704.1
Бараа материал	252,701.8	33,668.6	-219,033.1
Үндсэн хөрөнгө	4,669,819.3	1,959,416.0	-2,710,403.3
Нийт хөрөнгө	**5,756,338.1**	**2,575,328.4**	-3,181,009.7
Өр төлбөр	70,810.2	-	-70,810.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,685,528.0	2,575,328.4	-3,110,199.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**5,756,338.1**	**2,575,328.4**	-3,181,009.7

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансуудын өөрчлөлтийг авч үзэхэд дараах байдалтай байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 662,150.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 404,873.4 мянган төгрөг болж, 257,277.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	662,150.8	404,873.4	-257,277.4
Төрийн сангийн харилцах	662,150.8	404,873.4	-257,277.4
Дүн	662,150.8	404,873.4	-257,277.4

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан 250,217.0 мянган төгрөг ОНЕО-ын дансанд, 65,826.0 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 88,821.3 мянган төгрөг ХХС-ийн дансанд, 9.1 мянган төгрөг ИТХ-ын дансанд тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 171,666.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 177,370.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,704.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	11,499.6	-	-11,499.6
Татаас, санхүүжилтийн авлага	9,641.1	-	-9,641.1
Зээлийн хүүгийн авлага	6,276.1	5,404.4	-871.7
Байгууллагаас авах авлага	27.4	-	-27.4
Хувь хүмүүсээс авах авлага	1,789.0	-	-1,789.0
Зээлийн авлага	142,433.2	171,966.1	29,532.9
Дүн	**171,666.4**	**177,370.5**	**5,704.1**

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд ХХС-ийн зээлийн 171,966.1 мянган төгрөгийн, хүүгийн 5,404.4 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт

- *Тайлант онд ХХС-аас 3 аж ахуйн нэгж байгууллагад хөнгөлөлттэй зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх ажлын хэсэг байгуулаагүй, барьцаа хөрөнгө зээлийн дүнд хүрсэн эсэхийг үнэлэлгүйгээр олгосон байна.*

3.4.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 252,701.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 33,668.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 219,033.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	**33,874.8**	**-**	**-33,874.8**
Тусгай зориулалттай материал	14,932.9	-	-14,932.9
Эм боох материал	18,941.9	-	-18,941.9
Бэлэн бүтээгдэхүүн	**-**	**-**	**-**
Хангамжийн материал	**218,826.9**	**-**	**-218,826.9**
Бичиг хэргийн материал	**18,947.9**	**1,103.5**	**-17,844.4**
Аж ахуйн материал	130,005.5	14,781.8	-115,223.7
Сэлбэг хэрэгсэл	123.6	-	-123.6
Түлш, шатах тослох материал	159.0	159.0	-
Хүнсний материал	2,992.5	1,166.7	-1,825.8
Бусад хангамжийн материал	66,598.4	16,457.6	-50,140.8
Дүн	**252,701.7**	**33,668.6**	**-219,033.1**

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орхон сумын ТТЗ-ийн дүнгээр нийт 298,164.8 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 296,001.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, 221,196.8 мянган төгрөгийн материалыг бүтцийн өөрчлөлтөөр данс бүртгэлээс хассан байна.

Тайлант онд сумын боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн тайлан харьяа яамдын санхүүгийн тайланд нэгтгэгддэг болсноос шалтгаалж бараа материалын дансны үлдэгдэл буурсан байна.

Аудитын илрүүлэлт

- *ЗДТГ нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн бариимтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй нийт* **1,744.7** *мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан.*

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,911,896.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,636,405.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,275,491.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	3,889,700.7	989,983.3	-2,899,717.3
Авто-тээврийн хэрэгсэл	187,205.6	239,707.1	52,501.5
Машин тоног төхөөрөмж	441,709.6	128,564.7	-313,144.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	145,436.2	52,817.4	-92,618.8
Зам, гүүрийн байгууламж	529,187.6	578,283.5	49,095.9
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	14,000.0	14,000.0	-
Бусад үндсэн хөрөнгө	609,853.0	601,707.1	-8,145.9
Ном	22,867.8	200.0	-22,667.8
Программ хангамж	7,190.0	3,950.0	-3,240.0
Бусад биет бус хөрөнгө	64,746.3	27,192.3	-37,554.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	**5,911,896.8**	**2,636,405.5**	**-3,275,491.3**

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,275,491.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 212,829.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, ОНХС-аас 68,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, 15,037.6 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг ДЗОУБ-аас хандиваар авсан болон 7,287.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, бүтцийн өөрчлөлтөөр 3,564,070.5 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассан зэргээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт

1. *Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,720.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй /ИТХ нь 1,220.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, ХХС нь 1,500.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер/,*
2. *Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжиж, ашиглалтад хүлээн авсан 125,274.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээг ЗДТГ-т хүлээлгэн өгсөн боловч холбогдох данс, бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:*
   - *Хөтөл цэнэг ХХК-ний хэрэгжүүлсэн "Гэрэлтүүлгийн өргөтгөл, засвар шинэчлэлт хийх" 20,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ*
   - *БИММ ХХК-ий хэрэгжүүлсэн "Бэлэндалай багт бэлчээрийн худаг гаргах"25,901.6 мянган төгрөг төсөл, арга хэмжээ*
   - *БИММ ХХК-ий хэрэгжүүлсэн "Ходоолой багт худаг гаргах" 39,372.6 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ*
   - *Хөтөлийн Анар ХХК-ийн гүйцэтгэсэн "42-р зөрлөг, шийр сууринд хогийн цэг байгуулах" 20,000.0 мянган төгрөгийн хашаа,*
   - *Тэс бялдаржуулах төвийн хэрэгжүүлсэн "Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж худалдан авах" 20,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ.*

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 70,810.2 мянган төгрөг байсан бол жилийн эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	3,266.8	-	-3,266.8
Бараа үйлчилгээний зардлын өглөг	49,216.1	-	-49,216.1
Байгууллагад төлөх өглөг	18,327.3	-	-18,327.3
Дүн	70,810.2	-	-70,810.2

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны өмнөх оны үлдэгдэлд тайлагнагдсан 62,435.7 мянган төгрөг нь эрүүл мэнд, боловсрол, соёлын байгууллагуудын өглөг байсан бол 8,374.5 мянган төгрөгийн өглөг нь ЗДТГ-аас Эл Си Би ХХК-д төлөх халаалтын төлбөрийн өглөг бүртгэлтэй байсныг тайлант онд бүрэн барагдуулсан.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,685,528.0 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,575,328.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,110,199.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	906,101.3	262,048.7	-644,052.6
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	906,101.3	262,048.7	-644,052.6
Хуримтлагдсан үр дүн	4,131,077.5	2,187,651.6	-1,943,425.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	648,349.2	125,628.1	-522,721.1
Дүн	**5,685,528.0**	**2,575,328.4**	**-3,110,199.5**

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3,110,199.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүн буурснаас шалтгаалсан байна.

3.4.7 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **22,279.0** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт

Иргэдийн төлөөлөгчийн Хурал:

- *ЖМС-аар анхан шатны баримтын бүрдэлгүй/ бэлэн мөнгө хүссэн өргөдөл, олгох зөвшөөрөлгүй болон зарцуулалтыг нотлох гүйцэтгэлийн тайлан гаргаагүй/ нийт **810.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,*
- *Багаж, техник, хэрэгслийн зардлаас **472.8** мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас сумын нас барсан иргэдийн ар гэрт буцалтгүй тусламж болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хамаарах уралдаан, тэмцээн, арга хэмжээг зохион байгуулахад **2,070.0** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.*

Засаг даргын Тамгын газар:

- *Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон Ж.Жаргалдалайд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тооцож олгохдоо 1995-2000 оны*

*хооронд нөхөн даатгалаар тооцуулсан 5 жилийг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож **2,549.3** мянган төгрөгийг илүү олгосон,*

- *ЖМС-аар анхан шатны бариитын бүрдэлгүй/ бэлэн мөнгө хүссэн өргөдөл, олгох зөвшөөрөлгүй болон зарцуулалтыг нотлох гүйцэтгэлийн тайлан гаргаагүй/ нийт **9,706.9** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,*
- *Өмч хамгаалах зөвлөлөөр автомашинд засвар, үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх техникийн комиссын дүгнэлт гаргалгүйгээр **6,670.0** мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийж бүртгэл, тайланд тусгасан байна.*

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн татварын болон татварын бус орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөв батлах тухай 2022 оны 39 дүгээр тогтоолоор тайлант онд 319,037.7 мянган төгрөгийн татварын орлого, 36,000.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 409,297.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 15.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	91,000.0	96,733.6	5,733.6	106.3
Үйл ажиллагааны орлого	16,100.0	23,314.8	7,214.8	144.8
Хөрөнгийн орлого	8,300.0	5,601.3	(2,698.7)	67.5
Хөрөнгө борлуулсны орлого	5,100.0	4,440.0	(660.0)	87.1
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1,400.0	1,163.1	(236.9)	83.1
Бууны албан татвар	950.0	720.0	(230.0)	75.8
Малд ногдуулах албан татвар	100,500.3	104,527.0	4,026.7	104.0
Улсын тэмдэгтийн хураамж	6,000.0	5,141.6	(858.4)	85.7
Түгээмэл тархацтай АМ ашигласны төлбөр	451.0	240.0	(211.0)	53.2
Газрын дуудлага худалдаа	9,600.0	14,777.6	5,177.6	153.9
Газрын төлбөр	77,446.4	57,145.2	(20,301.2)	73.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,000.0	-	(2,000.0)	-
Агнуурын нөөц ашигласны төлбөр	100.0	-	(100.0)	-
Байгалийн ургамал ашигласны төлбөр	90.0	27,633.2	27,543.2	307 дах
Ойн нөөц ашигласны төлбөр	-	22.5	22.5	-
Бусад орлого	3,000.0	14,601.2	11,601.2	486.7
Торгуулийн орлого	33,000.0	53,236.0	20,236.0	161.3
Нийт дүн	**355,037.7**	**409,297.1**	**54,259.4**	**115.3**

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелсэн нь цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого 5,733.6 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 7,214.8 мянган төгрөгөөр, малд ногдуулах албан татвар

4,026.7 мянган төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлого 5,177.6 мянган төгрөгөөр, байгалийн ургамал ашигласны төлбөр 27,543.2 мянган төгрөгөөр, бусад орлого 11,601.2 мянган төгрөгөөр, торгуулийн орлого 20,236.0 мянган төгрөгөөр тус тус давж биелснээс шалтгаалсан байна.

Харин хөрөнгийн орлого 2,698.7 мянган төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 236.9 мянган төгрөгөөр, бууны албан татвар 230.0 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 858.4 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 211.0 мянган төгрөгөөр, газрын төлбөр 20,301.2 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2,000.0 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөр 100.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

<u>Давсан орлого</u>

- Тайлант онд цалин хөлс өссөнөөс шалтгаалж хувь хүний орлогын албан татварын орлого 5,733.6 мянган төгрөгөөр давсан,
- Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааны орлого нэмэгдсэнээс шалтгаалж хувь хүний үйл ажиллагааны орлогод ногдох татвар, хураамж 7,214.8 мянган төгрөгөөр давсан,
- Малд ногдуулах албан татварын орлогын төлөвлөгөө 4,026.7 мянган төгрөгөөр давсан нь малын тоо толгойг үнэн зөв төлөвлөөгүйгээс шалтгаалсан,
- Бусад орлого 11,601.2 мянган төгрөгөөр давсан нь орлогын төлөвлөгөөг багаар төлөвлөснөөс шалтгаалсан,
- Торгуулийн орлого 20,236.0 мянган төгрөгөөр давсан нь байгаль орчны улсын байцаагчийн тогтоосон акт болон сумын нутаг, дэвсгэрээр дамжин өнгөрөх */Дархан-Уул болон Орхон аймгийн чиглэлд зорчих хөдөлгөөний/* авто замаар зорчсон жолооч нарын авто тээврийн хөдөлгөөн болон замын хөдөлгөөний зөрчил нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

<u>Тасарсан орлого</u>

- Газрын төлбөр 20,301.2 мянган төгрөгөөр тасарсан нь газрын бүртгэлд шинэчлэлт хийгдэж цахим болсонтой холбоотойгоос гадна тус сум татварын улсын байцаагчгүйгээс шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг тус бүр 1,983,835.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 32 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 355,037.7 мянган төгрөгөөр, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 791,713.4 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 171,834.1 мянган төгрөгөөр, ХХС-ийн зээлийн эргэн

төлөлтийг 154,250.0 мянган төгрөгөөр, сумын төсвийн урьд оны үлдэгдлээс 508,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлогоос 3,000.0 мянган төгрөг зэрэг нийт **1,983,835.2** мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 39 дүгээр тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого, зарлагыг бууруулж тус бүр **1,915,311.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 68,523.8 мянган төгрөгөөр, бууруулж тодотгосон,
- ТЗШ-ийн байгууллагуудад олгох тогтмол зардлын санхүүжилтийг 68,523.8 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор төсвийн орлого, зарлагыг 68,523.8 мянган төгрөгөөр бууруулж **1,915,311.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 */ИТХ 2, ЗДТГ4, ОНХС 1, ХХС 1/* хөтөлбөрийн 29 */ИТХ 6, ЗДТГ 17, ОНХС 4, ХХС 2/* арга хэмжээг санхүүжүүлэхээр сумын төсвийн орлогыг 355,037.7 мянган төгрөгөөр, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 723,189.6 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 171,834.1 мянган төгрөгөөр, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 154,250.0 мянган төгрөг, сумын төсвийн урьд оны үлдэгдлээс 508,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлогоос 3,000.0 мянган төгрөг зэрэг нийт **1,915,311.4** мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 723,189.6 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 171,834.1 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 293,713.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 92,232.1 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 409,297.1 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 2,332.3 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, нийт **1,692,598.4** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,652,645.8 мянган төгрөг буюу 86.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 262,665.6 мянган төгрөгөөр, боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагад олгох тогтмол зардлын санхүүжилтийг 114,874.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 248,640.0 мянган төгрөг */аймгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээний 179,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 1 төсөл арга хэмжээний 15,000.0 мянган*

төгрөг, аймгийн замын сангийн эх үүсвэрээр хийгдсэн 49,992.5 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээний санхүүжилт болон аймгийн Засаг даргын А/82, А/169, А/402 дугаар захирамжаар 4,347.5 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас хамтарсан багийн санхүүжилтэд 300.0 мянган төгрөг/, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 4,300.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 4,497.6 мянган төгрөгийн нэмэлт орлогыг тус тус бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 2,100.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 3,530.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 6,240.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 50,859.2 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 10,376.5 мянган төгрөг, 193,246.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Орхон сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн өмч хамгаалах зөвлөлийн техникийн комиссын дүгнэлт гаргуулж автомашинд засвар, үйлчилгээ хийж байх, ХХС-аас олгох зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн зээл олгож байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон сумын ТТЗ-ийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тус ТТЗ-ийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,027,860.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 60,557.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн тайлан харьяа яамдад нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүн болох 1,138,654.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар тооцон 22,773.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт 18 төрлийн чиглэл хүргүүлсний дагуу дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын батлагдсан төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар жилийн эцэст батлагдсан төсвийг 13.7 хувиар хэмнэсэн,
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудыг авлага, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажилласан,
- Хоршоог хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн 12 зээлдэгчийн авлагыг барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласны үр дүнд 18,616.1 мянган төгрөгийн чанаргүй зээлийг төлүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 10. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Огт мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	168	96	59	13
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	128	43	-
3	Засаг даргын Тамгын газар	171	118	53	-
	Нийт дүн	**510**	**342**	**155**	**13**

Эх сурвалж: www.old.shilendans.gov.mn

ТТЗ болон харьяа байгууллагууд нь мэдээлбэл зохих 510 мэдээллээс 342 мэдээллийг хугацаанд нь, 155 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 13 мэдээллийг огт мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: *"Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратегийг боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 89,985.4 мянган төгрөгийн 10 зөрчил илрүүлж, 3,105.1 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 9,456.3 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж , 77,424.0 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	3,105.1	3	3,105.1	100.0
Албан шаардлага	4	9,456.3	4	9,456.3	100.0
Зөвлөмж	3	77,424.0	2	69,155.1	66.6
Нийт дүн	**10**	**89,985.4**	**9**	**81,716.5**	**90.0**

Өмнөх аудитаар өгсөн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж байх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох"* журмын 4.2.1 дэх *"Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана"*, 4.2.1.10: *"Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг шалгаж амжаагүй тул Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

Засаг даргын орлогчоор ажиллаж байсан Г.Баасансүрэнд сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн гэж **5,340.1** мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгох Засаг даргын 2022 оны Б/22 дугаар захирамжийн хууль, эрх зүйн актыг буруу сонгож хэрэглэсэн байна. Өөрөөр хэлбэл Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, 82.3 дугаар зүйлийг бус Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх "*Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно"* гэсэн заалтыг үндэслэсэн байна. Цаашид захирамжийн хууль, эрх зүйн үндэслэлийг зөв сонгож хэрэглэх нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **127,994.1** мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг залруулагдаагүй алдаагаар бүртгэж, зөвлөмж өгөв. Үүнд:

1. Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,720.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй */ИТХ нь 1,220.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, ХХС нь 1,500.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер/*

2. Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжиж, ашиглалтад хүлээн авсан 125,274.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээг сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн боловч холбогдох данс, бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:
   - Хөтөл цэнэг ХХК-ний хэрэгжүүлсэн "Гэрэлтүүлгийн өргөтгөл, засвар шинэчлэлт хийх" 20,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ
   - БИММ ХХК-ий хэрэгжүүлсэн "Бэлэндалай багт бэлчээрийн худаг гаргах"25,901.6 мянган төгрөг төсөл, арга хэмжээ
   - БИММ ХХК-ий хэрэгжүүлсэн "Ходоолой багт худаг гаргах" 39,372.6 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ
   - Хөтөлийн Анар ХХК-ий гүйцэтгэсэн "42-р зөрлөг, шийр сууринд хогийн цэг байгуулах" 20,000.0 мянган төгрөгийн хашаа,
   - Тэс бялдаржуулах төвийн хэрэгжүүлсэн "Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж худалдан авах" 20,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д *"...байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ...хөрөнгө, эх үүсвэрийн* хөдлөл, өөрчлөлт бүрийг *анхан шатны бариманд бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна"* гэж заасныг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэлт:</u> 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийж, алдааг залруулах зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 24,023.7 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 2,549.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14,804.4 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 6,670.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон Ж.Жаргалдалайд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тооцож олгохдоо 1995-2000 оны хооронд нөхөн даатгалаар тооцуулсан 5 жилийг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож **2,549.3** мянган төгрөг илүү олгосон байна.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*", Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 3.1 дэх *"Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно"*, 3.1.12: "*нийгмийн шилжилтийн явцад ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний* ***1990-1995 оны хооронд*** *ажилласан жил тасарсан иргэнд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагаас зохих журмын дагуу олгосон баталгаажилтын хуудсыг үндэслэн ажилласнаар нөхөн тооцуулсан хугацаа"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Илүү олгосон нэг удаагийн буцалтгүй тусламжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Иргэдийн төлөөлөгчдийн Хурал

5.2.1 Багаж, техник, хэрэгслийн батлагдсан төсвөөс 472.8 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын батлагдсан төсвөөс сумын нас барсан иргэдийн ар гэрт буцалтгүй тусламж болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хамаарах уралдаан, тэмцээн, арга хэмжээний шагналд 2,070.0 мянган төгрөг зэрэг нийт **2,542.8** мянган төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын *Багаж, техник, хэрэгсэл:* "*Байгууллагын үндсэн үйл ажиллагааны зориулалтаар ашиглахаар худалдан авах багаж, техник, хэрэгсэл...зэрэг тоног төхөөрөмж энд багтана.", Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшил: "Байгууллагын дотоод журамд заасны дагуу* ***албан хаагчид голдуу хагас болон бүтэн жилийн эцэст нэг удаа олгох*** *мөнгөн шагнал, урамшуулал, эсхүл журамд заасан нөхцөлөөр олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардал энд хамаарна"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Засаг даргын Тамгын газар

5.2.2 Өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс 1,744.7 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь "*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*",

Сангийн сайдын Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм* " гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэн, бүртгэж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 ЖМС-аар анхан шатны баримтын бүрдэлгүй */ бэлэн мөнгө хүссэн өргөдөл, олгох зөвшөөрөлгүй болон зарцуулалтыг нотлох гүйцэтгэлийн тайлан гаргаагүй/* нийт **10,516.9** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- *ИТХ 810.0 мянган төгрөг,*
- *ЗДТГ-ын 9,706.9 мянган төгрөг.*

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.8 дахь "*Мөнгөн кассын нярав нь анхан шатны орлого, зарлагын баримтыг үндэслэн мөнгөн кассын гүйлгээг хийнэ*", 3.9 дэх "*Мөнгөн кассаар дамжуулан хийгдэх гүйлгээ бүрд орлого, зарлагын баримтыг бичиж байна*" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ЗДТГ нь Өмч хамгаалах зөвлөлөөр автомашинд засвар, үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх техникийн комиссын акт, дүгнэлт гаргалгүйгээр **6,670.0** мянган төгрөгийн засвар, үйлчилгээг гүйцэтгэж бүртгэл, тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

2. **Хоршоог хөгжүүлэх сантай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант онд ХХС-аас олгосон зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх ажлын хэсэг байгуулаагүй, барьцаа хөрөнгө зээлийн дүнд хүрсэн эсэхийг үнэлэлгүйгээр олгосон байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.4 дэх "*Энэ журмын 3.4.3-т заасны дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаалах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан дүгнэлт гаргуулах бөгөөд үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлэх*" гэсэн заалыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ХХС-аас олгож байгаа зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээг холбогдох журмын үнэлэх ажлын хэсэг байгуулж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгуулл агын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	1	1,220.0	1	1,220.0					1	1,220.0	1	1,220.0
ЗДТГ	1	125,274.1	1	125,274.1					1	125,274.1	1	125,274.1
ХХС	1	1,500.0	1	1,500.0					1	1,500.0	1	1,500.0
Дүн	3	127,994.1	3	127,994.1					3	127,994.1	3	127,994.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгуу ллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	1	-					1	-				
ИТХ	2	3,352.8			2	3,352.8						
ЗДТГ	4	20,670.9	1	2,549.3	2	11,451.6	1	6,670.0				
Дүн	**8**	**24,023.7**	**1**	**2,549.3**	**4**	**14,804.4**	**2**	**6,670.0**				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	59				59			
ТТЗ шилэн дансны мэдээллийг огт мэдээлээгүй	13				13			
ИТХ ТТЗ шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	43				43			
ЗДТГ ТТЗ шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	53				53			
Дүн	**168**				**168**			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	**168**				**168**			